

ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАРЫН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2009 ОН

МОНГОЛ УЛСЫН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БҮСИЙН НЭМЭГДЭЛД ХАМААРАГДАХ “БИЧИЛ БҮС” ТОГТООХ СУДАЛГАА, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-09/102
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Батсүх, Б.Буяндэлгэр, Д.Золбоо, Д.Живгаагүнсэл, Ц.Түвшинзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн Р.Амаржаргал
Огноо: 2009.05.11
Сэдвийн агуулга: Судалгаанд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, түүний онолын үндэслэл, Монгол Улсад бүсийн нэмэгдэл олгож байсан туршлага, холбогдох хууль эрх зүйн актуудын талаарх мэдээлэл, Гадаад орнуудын бүсийн нэмэгдэл олгож буй туршлага (ОХУ, Канад, Казахстан), Монгол Улсын “бүсийн нэмэгдэл”-д хамаарагдах шаардлагатай бүс нутгийг илрүүлэх судалгаа, судалгааны дүгнэлт, санал зөвлөмж зэргийг хамруулсан.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Судалгааны код: СТ-09/104
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ч.Базар
Захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Сэдванчиг
Огноо: 2009.05.07
Сэдвийн агуулга: Уг бодлогын судалгаанд (1) Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний өнөөгийн байдал, (2) Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин, (3) ТХГН-ийн эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох нь, (4) ТХГН-т тулгарч буй хүндрэлтэй асуудал, (5) ТХГН-ийн байгалийн баялгийг хамгаалах, ашиглахад нутгийн иргэдийн оролцоог түшиглэн хөгжсөн сайн туршлагын талаар тодорхой оруулсан.

ЗАСГИЙН ГАЗРААС УИХ-Д ӨРГӨН БАРЬСАН ОЮУ ТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ГЭРЭЭНИЙ ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны код: СТ-09/106
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Г.Алтан-Оч, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа
Захиалагч: Эдийн засгийн байнгын хороо
Огноо: 2009.04.25
Сэдвийн агуулга: Судалгаанд Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд тусгагдсан тогтворжуулсан болон тогтворжуулаагүй татварын төрөл, хувь, хэмжээ түүний үр дагавар, Оюу толгой төслөөс хүртэх хөрөнгө оруулалтын өгөөж, зээл эргэн төлөгдөх хугацааны тооцоо, түүнчлэн Хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд тусгасан зөрчилтэй асуудлууд, судалгааны дүгнэлт, сайжруулах бодлогын хувилбарууд, Айвенхоу майнз групп, түүнд хамааралтай этгээдүүдийн хоорондын холбоо, харилцан хамаарал,

компанийн бүтэц, үйл ажиллагаа, хөрөнгийн талаар судалгаа шинжилгээ хийсэн.

ДЭЛХИЙН УРАНЫ ЗАХ ЗЭЭЛ, ЦӨМИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, БУСАД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-09/107
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Н.Түвшинтөгс, Г.Алтан-Оч, Б.Ариунжаргал, Ц.Болормаа, С.Дорждагва, Б.Мөнхцэцэг, Д.Мягмарцэрэн
Захиалагч: УИХ-ын гишүүн П.Алтангэрэл
Огноо: 2009.05.15
Сэдвийн агуулга: Энэхүү бодлогын судалгаанд (1) дэлхийн ураны зах зээлийн талаарх мэдээлэл-судалгаа, (2) уран олборлох, ашиглах харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны харьцуулсан судалгаа, бусад орнуудын туршлага, (3) жижиг оврын атомын цахилгаан станц, цөмийн эрчим хүчний шинэ техник, технологийн мэдээлэл, (4) Монгол Улсын ураны хайгуул, нөөц, олборлолтын мэдээлэл, (5) Цацрагийн асуудлаар Монгол Улсын хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, уран ашиглах, олборлох харилцааг зохицуулах шаардлага, Олон улсын атомын энергийн аюулгүй байдлын стандартад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлт зэргийг багтаасан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛ УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-09/109
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ч.Базар (Ph.D)
Захиалагч: УИХ-ЫН Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009.11.06
Сэдвийн агуулга: Энэхүү бодлогын судалгаагаар уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлтийн өнөөгийн байдлыг мэргэжлийн байгууллагуудын гаргасан тоон үзүүлэлт дээр түшиглэн гаргалаа. Мэдээлэл цуглуулах явцад улсын хэмжээний техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн талаарх мэргэжлийн байгууллагуудын гаргасан тоон мэдээлэл нэлээд их зөрүүтэй байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд уул уурхайн нөхөн сэргээлт өссөн дүнтэй байгаа нь нааштай үзүүлэлт юм. Харин нөхөн сэргээлт хийх буюу бүхэлдээ байгаль орчныг хамгаалах бодлого дэлхий нийтэд хүний аюулгүй амьдрах орчинтой уялдан, түүний салшгүй хэсэг болох хүний эрхэд түшиглэсэн бодлого баримталж байна. Байгаль орчинтой холбоотой аливаа асуудалд хүний мэдээлэл авах, түгээх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрхээ хамгаалуулах эрхийг хүндэтгэх, аливаа шийдвэр гаргахад иргэд болон ИНБ-ын оролцоог дээдлэх, хяналтыг төрийн байгууллага нь иргэд, ИНБ-тай хамтран хийх, эхний төлөвлөлт болон эцсийн гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй танилцуулах замаар “Байгаль орчны шударга ёс, эрх”-ийн асуудалд тулгуурлан ажиллах бодлогыг дэлхийн олон улс оронд хэрэгжүүлж байна. Уул уурхайн болон байгалийн бусад баялгийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил болгон ашиглахад “Байгаль орчны шударга ёс, эрх”-ийг хүндэтгэх нь тэрхүү бодлогын тулгуур зарчим юм. Энэхүү судалгаанд дээрх чиглэлийг баримтлан ажиллаж амжилтад хүрч буй зарим улс орны туршлага, арга зүйг эрх зүйн хүрээнд нь харуулсны зэрэгцээ, өнөөдөр Монгол Улсад хэрэгжүүлж буй байгаль орчныг хамгаалах хууль, эрх зүйн баримт бичигт задлан шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид анхаарах бодлого, зохицуулалтыг санал, зөвлөмж маягаар тусгалаа.

АШИГТ МАЛТМАЛЫН САЛБАРТ ХИЙГДЭЖ БАЙГАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ТАЛААР

<i>Судалгааны код:</i>	СТ-09/201
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Д.Мягмарцэрэн, Ц.Батбаяр
<i>Захиалагч:</i>	Байнгын хорооны ажлын алба Д.Одсүрэн
<i>Огноо:</i>	2009.02.10
<i>Сэдвийн агуулга:</i>	Харьцуулсан судалгаанд (1) Өмнөд Америк, Зүүн өмнөд Ази, Африк тивийн зарим улс орнууд, түүнчлэн ОХУ энэхүү гэрээг хийхдээ ямар эрх зүйн актыг үндэслэн байгуулж байгаа, (2) Гэрээний үндсэн зарчим, түүний агуулга ямар байгаа, тухайлбал төрийн оролцоо, эзэмшлийн хувь хэмжээг тогтоох зарчим, ашиг хуваарилах зарчим, бүтээгдэхүүн хуваах зарчим зэргийн талаар, тэдгээрийн давуу болон сул талууд, (3) Гэрээнд тусгадаг албан татварын талаарх асуудал: Тухайлбал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлдэг эсэх, гэрээний хугацаа дуусаагүй байхад татварын хувь хэмжээ нэмэгдэх, буурах нөхцөлд гэрээгээ өөрчилдөг эсэх, шинээр бий болсон татварын талаар гэрээнд нэмж тусгаж болдог эсэх, (4) Гэрээний хугацаа хэдэн жилээр хийдэг, дахин сунгадаг эсэх, сунгах тохиолдолд гэрээндээ өөрчлөлт оруулдаг эсэх, (5) Гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг, зөвхөн гэрээгээр тохиролцсон тохиолдолд өөрчлөлт оруулах эсхүл хууль тогтоомжоор нь өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн байдаг эсэх, (6) Гэрээ байгуулах үйл явцын болон гэрээний хэрэгжилтийн талаар олон нийтэд ил тод мэдээлж байх асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал зэргийн хөндсөн.

АШИГТ МАЛТМАЛЫН ОРД АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ТАЛААРХИ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-09/203
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ч.Базар, С.Дорждагва
<i>Захиалагч:</i>	УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
<i>Огноо:</i>	2009.04.05
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгааны Тогтвортой байдлын гэрээний тухай ерөнхий ойлголт, бусад орны туршлага гэсэн 1-р бүлэгт Ашигт малтмалыг олборлох, ашиглахтай холбоотой санхүүгийн дэглэм, Уул уурхайн гэрээний ялгаанууд, Хөрөнгө оруулагчийн анхаарах зүйлс, Засгийн газрын анхаарах зүйлс, Тогтвортой байдлын гэрээний хэрэглээ ба түүнийг буруугаар ашиглах, Тогтвортой байдлын гэрээний талаарх Монгол Улсын хуулиуд дах зөрчлүүд, Тогтвортой байдлын гэрээний сайн ба муу туршлагауд, Нийтлэг асуудал, бэрхшээлүүд зэргийг, Уул уурхайн салбар дах санхүү, татварын асуудал, Олон улсын туршлага гэсэн 2-р бүлэгт Санхүүгийн өөрчлөлт, шинэчлэлтийн цар хүрээ, Татварын хэлбэрүүд болон гэрээний төсөлд тусгагдсан байдал, Татварын тогтворжуулалт зэргийг хамруулсан. 3, 4-р бүлэгт Оюу толгойн орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний зарим асуудлыг бусад орны жишээн дээр харьцуулалт, Уул уурхайн салбар дахь төрийн оролцоонд тулгарч болох бэрхшээлийг хөндсөн байна.

МОНГОЛ, ФРАНЦ ХОЁР УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

<i>Судалгааны код:</i>	СТ-09/209
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж

Огноо: 2009.06.03
Сэдвийн агуулга: Монгол болон Франц хоёр улсын ашигт малтмал ашиглах тухай хууль нь зарим нэг тодорхой зохицуулалтын хувьд адил гэж үзэж болохуйц боловч ерөнхий суурь зарчмын хувьд ихээхэн ялгаатай болох нь судалгааны явцад харагдлаа. Энэхүү ялгаа нь тухайн улс бүрийн эдийн засаг, улс төр, нийгмийн шинжтэй үндсэн ялгаан дээр тулгуурлан бий болсон байна. Эдгээрийг гаргахдаа хуулиудыг заалт бүрээр нь харьцуулах хэлбэрээр бус гол зохицуулалтын хэсгүүдээр нь харуулсан болно. Энэ нь: Ашигт малтмалын өмчлөл, Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, Олборлолтын гэрээ, Байгаль орчныг хамгаалах болон бусад хохирол эрсдлээс урьдчилан сэргийлэх, Ашигт малтмалаас олох орлого гэсэн хэсгүүд юм.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ БА ТӨРИЙН ДЭМЖЛЭГ

Судалгааны код: СТ-09/210
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, Ц.Батдорж, Г.Билгээ, Ц.Түвшинзаяа, Ц.Болормаа, А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Занданшатар
Огноо: 2009 он
Сэдвийн агуулга: Энэхүү харьцуулсан судалгаагаар зарим улс орнуудын засгийн газруудын зүгээс жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилтэд төрөөс гаргадаг баталгааны төрлүүд, хувь хэмжээ, хугацаа, шимтгэл болон засгийн газрын баталгаат зээл авахад жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд тавигддаг шаардлага, дээрх харилцааг зохицуулдаг гол хууль тогтоомжуудын харьцуулсан мэдээллийг нэгтгэн танилцуулж байна. Мөн Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаар товч мэдээлэл орууллаа.

БИЧИЛ УУРХАЙ БОЛОН ГАР АРГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-09/212
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн, Г.Чулуун, Ч.Базар, Ц.Болормаа, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009.10.05
Сэдвийн агуулга: Монгол Улсад уул уурхайн салбарын харилцааг зохицуулах зорилгоор 1997 оноос "Ашигт малтмалын тухай" хууль болон түүнтэй холбоотой бусад тогтоол, дүрэм, журмуудыг батлан гаргасан. Гэвч иргэдийн гар аргаар ашигт малтмал олборлохтой холбогдсон аливаа харилцаа дээрх хууль болон дүрэм журмуудын зохицуулалтын гадна үлдсэн нь байгаль орчин болон нийгмийн харилцаанд олон сөрөг үр дагавар бий болгож байна.
Энэ харилцааг зохицуулахын тулд бие даасан хууль батлан гаргах нь зайлшгүй шаардлагатай гэдэг нь харагдаж байгаа ба дэлхийн бусад улс орнууд ч ийнхүү тусгайлсан хууль батлан гаргах замаар уг харилцааг зохицуулдаг байна.
Судалгаанд тулгамдсан асуудлуудыг зохистойгоор шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг хичээсэн болно. 2005 оноос эхлэн гаргаж байсан холбогдох хуулийн төслүүд, гадаадын зарим орны туршлага, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичиг, энэ асуудлаарх ТББ-ын судалгаа, мэдээлэл, 2001 оноос хойших хэвлэлүүдээр цацагдсан мэдээ баримт зэргийг харьцуулан судалсан болно.

ЭХ ҮҮСВЭР НЬ УУЛ УУРХАЙН ОРЛОГООС БҮРДДЭГ БАЯЛГИЙН САНГУУДЫН ЗАРЧИМ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Судалгааны код: СТ-09/215
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Судалгааг удирдсан: Ц.Норовдондог (Ph.D)
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч (Ph.D), Ч.Базар (Ph.D), Д.Мягмарцэрэн, А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Зоригт
Огноо: 2009.11.04
Сэдвийн агуулга: Уг судалгаанд уул уурхайн орлогоос эх үүсвэр нь бүрддэг баялгийн сангуудын талаарх лавлагаа мэдээллээс гадна Аляскийн байнгын сан, Чили улсын тогтвортой байдлын сан, Норвеги улсын төрийн тэтгэврийн сан, Казахстан улсын үндэсний сан зэрэг сангуудын зохицуулалтуудын туршлагыг судлан үзсэн..

Судалгааны баг уг асуудлаар нийт улс орнуудын холбогдох жишээ баримтуудыг судалж үзэхэд захиалгад дурдагдсантай шууд утгаараа адил нөөц баялгийн сан байдаггүй бөгөөд эдийн засгийг макро түвшинд, түүний дотор улсын төсвийг дунд, урт хугацаанд тогтворжуулах, үндэсний санхүүгийн хуримтлалыг бий болгон арвижуулж, эдийн засгийн хараат бус байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн мэдлийн нийт 56 хөрөнгийн сан байна. Эдгээр сангийн хөрөнгө нь нэгдүгээрт, тооцсон төсвийн төлөвлөгөөт орлогоос давсан төсвийн бодит бүх илүүдэл орлого ба төсвийн ашиг, хоёрдугаарт, уг сангийн үйл ажиллагаа буюу сангийн эх үүсвэрээр олон улсын санхүүгийн зах зээлд санхүүгийн хөрөнгө оруулалт хийсэн үйл ажиллагаанаас олсон нэмэлт орлогоос бүрддэг ажээ.

ӨНДӨР ТЕХНОЛОГИ /HIGH TECH/-ИЙН ҮҮРЭГ РОЛЬ, ТӨРИЙН БОДЛОГО, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-09/218
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: С.Дорждагва, Б.Мөнхцэцэг, Д.Золбоо
Захиалагч: УИХ-ыг гишүүн Н.Ганбямба
Огноо: 2009.11.06
Сэдвийн агуулга: **Орчин үед улс орнуудын хөгжлийн гол суурь хүч болж байгаа өндөр технологийг олон улсад хэрхэн хөгжүүлж байгаа, төрөөс баримталж буй бодлого, хэрэгжүүлэгч байгууллагуудын талаар харьцуулсан судалгаа хийхэд чиглэсэн болно.**

Судалгааг интернет дэх олон улсын байгууллагууд, дагнасан вебсайтуудаас мэдээлэл авч орчуулах, зарим статистик тоонд дүн шинжилгээ хийх, холбогдох судалгааны тайланг ашиглах аргаар хийлээ. Энд дурдсан мэдээллүүдийг дэлгэрүүлж үзэх боломжтой веб сайтууд болон судалгааны материалуудыг “Мэдээллийн эх сурвалж” хэсэгт оруулсан болно.

ГАДААД, ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ГАДААД ОРНУУДЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-09/221
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Түвшинзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2009 он
Сэдвийн агуулга: Харьцуулсан судалгаанд (1) Гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжийн тухай ойлголт, (2) Дотоодын хөрөнгө

оруулалт, (3) Гадаад орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтыг хамруулан судалсан болно.

“АТРЫН 3 ДАХ АЯН” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНД ХИЙСЭН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-09/301
Судалгааны төрөл: Тойм судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Батсүх, Д.Золбоо, Д.Живгаагүнсэл
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009
Сэдвийн агуулга: Судалгаанд технологийн шинэчлэл, тодруулбал, агротехникийн арга хэмжээ, хөдөө аж ахуйн техникийн бодлого, усалгаатай тариалан, хөрс хамгаалах ба үржил шимийг дээшлүүлэх, үр үйлдвэрлэл, хангамж зэргийг тоймлосон. Түүнчлэн боловсон хүчний хангамж, тэднийг бэлтгэх, хөтөлбөрийн эдийн засгийн бодлогын асуудал, хууль эрх зүйн зохицуулалт зэрэг асуудлуудыг хөндсөн.

ОЮУ ТОЛГОЙ ОРДЫГ АШИГЛАХ ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙН ТАЛААРХИ СУДЛААЧДЫН ШҮҮМЖ, ЗАРИМ ХАРЬЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-09/303
Судалгааны төрөл: Тойм судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун, Н.Түвшинтөгс
Захиалагч: Эдийн засгийн байнгын хороо
Огноо: 2009.04.05
Сэдвийн агуулга: Уг судалгаанд Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төслийн албан бус шүүмж, зарим харьцуулалтыг Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд, Оюутолгой төслийн хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд тус тус хийсэн. Мөн “Ашигт малтмалын тухай Монгол Улсын хууль”-д оруулсан өөрчлөлтүүд, зарим үр дагаврын талаар тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ХАЙГУУЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИЖ БАЙГАА ДОТООДЫН БОЛОН ГАДААДЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Судалгааны код: СТ-09/405
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Б.Мөнхцэцэг, Н.Түвшинтөгс
Захиалагч: УИХ-ын гишүүн З.Алтай
Огноо: 2009.05
Сэдвийн агуулга: Монгол Улсын хэмжээнд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай болон хамтарсан аж ахуйн нэгжүүдийн тоог харьяалах улсаар гаргасан. Мөн нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, хайгуулын тоо, талбай, ашиглалтын тоо, талбай зэрэг үзүүлэлтүүдийг гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн тоогоор ерөнхий гаргасан.

МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ БОРЛУУЛЖ БУЙ НЕФТЬ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ, ХИЛИЙН БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН, ЖИЖИГЛЭНГИЙН ҮНИЙН ТАЛААРХИ ХАРЬЦУУЛАЛТ (Шударга бус өрсөлдөөний аспект)

Судалгааны код: СТ-09/406
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Батдорж
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв

Огноо: 2009.05.06
Сэдвийн агуулга: Монголын шатахууны зах зээлийг цөөхөн тооны компани хариуцан ажилладаг зах зээлд үнэ тогтоохдоо үгсэн хуйвалдаж Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийг зөрчдөг боловч тодорхой арга хэмжээ авахгүй байгаа тухай олон эх сурвалжид хөндсөөр байгаа. Манай улсын зах зээл дээр газрын тосны бүтээгдэхүүний импорт, бусад үйлчилгээг явуулдаг 20 гаруй компани байдаг бөгөөд эдгээрээс шатахууны жижиглэнгийн борлуултын үйлчилгээ үзүүлдэг 6 компани байна. Эдгээрээс НИК, Петровис компани импортын шатахууны 40 шахам хувийг дангаараа нийлүүлдэг нь энэхүү зах зээлд өрсөлдөөн биш монополизм байдалтай гэж үзэж болохоор байна.

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ САЛБАРУУДАД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХЭД ТАВИХ ХЯЗГААРЛАЛТ, ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-09/407
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Ариунаа
Захиалагч: УИХ-ын гишүүн Н.Батбаяр
Огноо: 2009.05.06
Сэдвийн агуулга: Мэдээлэл лавлагааны зорилго нь бизнес-хөрөнгө оруулалтын хүрээ өргөжин тэлж байгаа глобалчлалын өнөө үед гадаадын компанид хөрөнгө оруулах болон гадаадын хөрөнгө оруулагчид стратегийн ач холбогдолтой үндэсний компанийн хувьцааг эзэмшихэд дэлхийн бусад орнуудад хуулиар тавьж буй хязгаарлалтууд, нийтлэг хандлага, хязгаарлалт тавих шаардлага, шалтгаан, ач холбогдлыг тодруулахад оршино.

МАЛЧДЫН ЗЭЭЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-09/409
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Батсүх, Д.Золбоо, Д.Живгаагүнсэл
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл
Огноо: 2009.05.06
Сэдвийн агуулга: УИХ-аас малчдын талаар төрөөс баримтлах бодлогын төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулан малчдын зээл, зээлийн эргэн төлөлт, зээлийн үлдэгдэл, зээлд барьцаалагдсан малын үнэ зэргийг холбогдох арилжааны банкуудаас ирүүлсэн судалгаанд тулгуурлан тооцоолж, төрөөс малчдын талаар баримтлах бодлого, чиглэлд зохих санал тусгуулах зорилгоор судалгааг гүйцэтгэв.

ДАРХАН ЦААЗАТ БОГДХАН УУЛАН ДАХ ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ГАРЧ БУЙ ЗӨРЧИЛ, АЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Судалгааны код: СТ-09/412
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ч.Базар, П.Мягмарцэрэн
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Энхбат
Огноо: 2009.06.22
Сэдвийн агуулга: Богдхан уулын дархан цаазат газрын талаарх товч мэдээ баримт, газар ашиглалтын байдал, түүний төлбөр, учирч буй бэрхшээл, газрын даац хэтэрсэн шалтгаан, сөрөг үр дагавар, түүнийг бууруулах арга зам, байгаль орчны доройтлын шалтгаан, түүнийг бууруулах арга зам, бусад асуудлуудыг судалсан. Түүнчлэн Богдхан уулын дархан цаазат газрын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ТХНГ-ийн ангилалд өөрчлөлт оруулах,

хил хязгаарыг өөрчлөх, үр дүнтэй менежмент бий болгох, Биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор зарим газрыг тусгай хамгаалалтад авах, Газар нутгийг тусгай хамгаалалтаас гаргах асуудлыг төрийн оновчтой бодлогоор шийдвэрлэх, нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжих, Олон улсын чанартай тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах үйл ажиллагааг идэвхжүүлэх, ТХГН-т аялал жуулчлал хөгжүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох зэрэг асуудлыг хөндсөн.

НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ, МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Судалгааны код: СТ-09/415
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Н.Түвшинтөгс, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа, Б.Ариунжаргал
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Бямбацогт
Огноо: 2009.11.04
Сэдвийн агуулга: Монгол Улсын нүүрсний зах зээлийн асуудлууд гэсэн бүлэгт нүүрсний нөөцийн судалгаа, экспортын хэмжээ, нүүрсний зах зээлийн үнийн судалгаа, нүүрсний экспортоос эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл, нүүрсний салбарын өнөөгийн практик нөхцөл байдал зэргийг багтаасан. Дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал, эрх зүйн орчны судалгаа гэсэн дараагийн бүлэгт дэлхийн нүүрсний зах зээлийн талаарх судалгаа, гадаад зах зээлийн эрэлт, нөөц болон үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч орнуудын эрх зүйн орчны мэдээлэл (АНУ, Австрали, БНХАУ, ОХУ), экспортыг нэмэгдүүлэх боломж, нүүрснээс нефтийн болон бусад төрлийн бүтээгдэхүүн гарган авах зэрэг асуудлуудыг хөндсөн.

2010 ОН

ХҮНСНИЙ САВ БООДОЛ, ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-10/101
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Батсүх /Ph.D, профессор/, Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2010.01.26
Сэдвийн агуулга: Бодлогын судалгаанд Савлагааны материал, Шилэн сав, Үйлдвэрлэлийн техник технологи, түүхий эдийн судалгаа болон Монгол Улсын хүнсний шилэн сав, баглаа боодлын хэрэгцээ, үйлдвэрлэлийн хөтөлбөрийг дэлгэрэнгүй авч үзсэн болно.

НИЙЛЭГ САВ БАГЛАА БООДЛООС ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИЛЖИХ ХИМИЙН ХОРТ БОДИСЫН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-10/102
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Батсүх /Ph.D, профессор/, Ө.Мөнхтунгалаг, Д.Живгаагүнсэл, Б.Ариунжаргал
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв

Огноо: 2010.01.30
Сэдвийн агуулга: Бодлогын судалгаанд Полимер (өндөр молекулт нэгдэл)-ийн тухай ангилал, гарган асах, физик болон механикийн шинж чанар, төлөв байдал, Хуванцрын ерөнхий шинж чанар, Полиэтилен, Полипропилен, Поливинилхлорид, Полиэтилентерефталат, Полимер материалыг хүнсний үйлдвэрт хэрэглэх, Нийлэг хальсан савлагаа, түүний давуу тал, Савлагааны төрөл зэрэг асуудлуудыг эхний бүлэгт багтаан судалсан. Хүнсний нийлэг сав баглаа боодлын стандартын хяналт болох 2 дахь бүлэгт Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, Хүнсний нийлэг сав баглаа боодлын техникийн ерөнхий шаардлага, Хуванцар лонхонд агуулсан хүнсний бүтээгдэхүүнд дам нөлөөлөх химийн бодисуудын зөвшөөрөгдөх хэмжээ (MNS 5580:2005), Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын ба нян судлалын үзүүлэлтүүдийн судалгаа зэргийг хамруулсан бол 3, 4-р бүлэгт Монгол Улсын хүнсний үйлдвэрүүдэд хэрэглэж байгаа хуванцар ба нийлэг сав баглаа боодлын судалгаа, Пластик материал ба хоол хүнсний аюулгүй байдлын талаар судалгаа хийсэн.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ЧИГЛЭСЭН ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны код: СТ-10/105
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2010.03.29
Сэдвийн агуулга: Тендер шалгаруулалт, түүний эрх зүйн орчин, өнөөгийн байдал (2008, 2009 оны тайланд тусгагдсанаар), төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тухай, 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний явц зэрэг асуудлуудыг хөндөж судалсан.

УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Судалгааны код: СТ-10/204
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа
Захиалагч: УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн
Огноо: 2010.02.04
Сэдвийн агуулга: Судалгаанд Австрали, Франц, Канад, ӨАБНУ, Чили, Перу, АНУ, ОХУ, Киргиз зэрэг гадаадын орнуудын Уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг харьцуулан судалсан.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БҮСЧИЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-10/205
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун, Ю.Эрдэнэтуяа, С.Дорждагва, Ш.Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа, Д.Живгаагүнсэл
Захиалагч: УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн
Огноо: 2010.02.04

Сэдвийн агуулга: Дэлхийн улс орнуудын орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай, Гадаадын зарим орнуудын нутаг дэвсгэрийн ангилал, хөгжлийн шалгуур үзүүлэлт зэрэг гадаадын зарим орны туршлага болон Монгол орны нутаг дэвсгэрийн ангилал, хөгжлийн өнөөгийн байдал, бүсчлэн хөгжүүлэх шаардлага, статистик мэдээлэл зэрэг сэдвийн хүрээнд судалсан.

УЛААНБААТАРЫН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛИЙН СУДАЛГААНУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код: СТ-10/206
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ч.Базар, Р.Батсүх, Б.Мөнхцэцэг, Т.Мягмаржав, А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Тэгбишдагва
Огноо: 2010. 03.23
Сэдвийн агуулга: Энэхүү харьцуулсан судалгаанд агаарын найрлага, чанарын стандарт, Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэрүүд, өнөөгийн байдал, зуух болон түлшнээс үүдэлтэй агаарын бохирдлын тухай, нийслэлийн чанарын албаны судалгаанд хамрагдсан шахмал ба коксожсон түлшний үзүүлэлтүүдийг харьцуулсан судалгааны нэгдсэн дүгнэлт, түлшний үйлдвэрүүдийн 2006-2009 онд авсан санхүүжилт болон гэрээний биелэлт, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зориулагдаж 2007-2009 онд улсын төсөвт батлагдсан төсөвт өртгийн судалгаа, Улаанбаатар хотын агаарын төлөв байдал, бохирдлын талаар хийсэн судалгаанууд, Улаанбаатар хотын агаарын бохирдол ба хүн амын эрүүл мэнд, агаарын бохирдлыг бууруулах эрх зүйн орчин, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр амжилт олсон зарим орны арга барил, цаашид ямар арга хэмжээ авах талаархи санал, зөвлөмжийг багтаасан.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Судалгааны код: СТ-10/210
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Батсүх, Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа, Д.Живгаагүнсэл
Захиалагч: УИХ-ын гишүүн Х.Наранхүү
Огноо: 2010.05
Сэдвийн агуулга: Уг харьцуулсан судалгаанд Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн төлөв байдал, Монгол Улсын эдийн засагт гүйцэтгэсэн үүрэг гэсэн эхний хэсэгт Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, Нэг хүнд ногдох хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь зэрэг асуудлуудыг, Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн судалгаа гэсэн дараагийн хэсэгт Мал аж ахуй хөдөө аж ахуйн гол салбар болох нь, Газар тариалан Монгол Улсын ХАА гол салбарын нэг болох нь зэрэг асуудлуудыг тус тус хөндсөн.

АШИГТ МАЛТМАЛЫН ЛИЦЕНЗ ОЛГОЛТЫН ТАЛААРХИ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-10/212
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын Ц.Шинэбаяр
Огноо: 2010.05.18
Сэдвийн агуулга: Судалгаанд бусад улс орнуудын туршлагыг жишээ болгон авахдаа тухайн улсын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох процессыг бүгдийг нь

дурьдахыг зориогүй бөгөөд зөвхөн өнөөдөр тус улсад үүсээд буй бэрхшээл асуудлыг шийдвэрлэж чадахуйц онцлог зохицуулалтуудыг сонгон авсан.

МОНГОЛ УЛС БОЛОН ӨМНӨД АВСТРАЛИ МУЖ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Судалгааны код: СТ-10/220
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ч.Базар, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Зоригт
Огноо: 2010.10.18
Сэдвийн агуулга: Австрали улсын уул уурхайн ашигт малтмалын зохицуулалтын талаархи товч мэдээлэл, Монгол Улсын “Ашигт малтмалын тухай хууль” болон Өмнөд Австрали мужийн “Уул уурхайн тухай” хуулийн зарим заалтыг харьцуулсан байдал, Нутгийн иргэдийн хамтлаг, нөхөрлөлтэй зөвлөлдөх нь - Өмнөд Австрали болон Холбооны хууль тогтоомж зэрэг асуудлын хүрээнд судлав.

ОЮУ ТОЛГОЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ, ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ГЭРЭЭ БОЛОН ТЕНХИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААРХИ ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН КОНТЕНТ-АНАЛИЗ

Судалгааны код: СТ-10/304
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Ч.Базар, Б.Мөнхцэцэг, Б.Ариунжаргал, С.Дорждагва, О.Нарантуяа, Ө.Мөнхтунгалаг, Д.Мягмарцэрэн, Н.Түвшинтөгс
Захиалагч: УИХ-ын дарга Д.Дэмбэрэл
Огноо: 2010.05.11
Сэдвийн агуулга: Энэхүү судалгааны зорилго нь “Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ”-г УИХ-аар соёрхон батлахын өмнөхөн буюу УИХ-ын 57, 40 дүгээр тогтоолын хүрээнд Засгийн газрын ажилласан байдал, улмаар УИХ-аас гэрээг соёрхон батлах явц болон түүний дараах үе, тус гэрээний ТЭЗҮ-ийг Засгийн газар болон Хөрөнгө оруулагч тал үзэглэхийн өмнөх, дараах үеийн цаг хугацаанд энэхүү үйл явцын талаарх бодлого, шийдвэр гаргагчид болон олон нийтийн санаа бодол ямар байсныг тандах, үүний үр дүнд ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах төрийн бодлого, шийдвэрт тус дэм үзүүлэхэд оршино. Бодлого шийдвэр гаргагчид гэдэгт УИХ, Засгийн газрын гишүүд, түүний харьяа төрийн байгууллагын төлөөлөл хамрагдах бол олон нийт гэдэгт иргэн, ИНБ, эрдэмтэн судлаачид, хөндлөнгийн шинжээчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон улсын байгууллагын төлөөллийг хамруулан ойлгоно. Төлөөллүүдийн санаа бодлыг тандахдаа өдөр тутмын сонины нийтлэл мэдээлэлд тулгуурласан болно. Судалгааны зорилго нь Гэрээ болон ТЭЗҮ-ийн ямар асуудлууд дээр төлөөллүүд шүүмжлэл өрнүүлж, түүнийг сайжруулах талаар ямар санал зөвлөмж гаргаж байгааг нэгтгэхэд чиглэгдсэн болно. “Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ” нь хүчин төгөлдөр болсон нөхцөл, цаг хугацааны хувьд олон, олон шүүмж, зөвлөмжийг дагуулсан боловч цаашид Монгол Улсын хуулиар стратегийн хэмээн жагсаагдсан ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахад бодлого, шийдвэр гаргагчдад тус хүргэхүйц мэдээлэл агуулж байгаараа энэхүү судалгаа нь ач холбогдолтой юм.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ, ХЭТИЙН ТӨЛӨВИЙН ТАЛААРХ СУДАЛГАА-МЭДЭЭЛЭЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-10/401
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Н.Түвшинтөгс, Б.Ариунжаргал
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Ж.Батсуурь
<i>Огноо:</i>	2010.02.10
<i>Сэдвийн агуулга:</i>	Энэхүү мэдээлэл лавлагаанд Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал болон цаашдын зорилт, хэтийн төлөвийг хамтатган судалсан. Эрчим хүчний салбарын өнөөгийн байдлын хүрээнд Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем, Эрчим хүчний үйлдвэрлэлийн чадлын бүтэц, Төвийн бүсийн цахилгаан станцууд ба ЦДАШ, Төвийн бүсэд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, Баруун бүсийн, Алтай-Улиастайн, Дорнод бүсийн, Өмнөд говийн бүсийн цахилгаан хангамжуудын талаар хавсаргав.

ЭРДЭС БАЯЛГИЙН АСУУДЛААР ГАДААД, ДОТООДЫН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

<i>Судалгааны код:</i>	СТ-10/402
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн
<i>Огноо:</i>	2010.02.04
<i>Сэдвийн агуулга:</i>	Тус лавлагаа мэдээллийг 18 эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын 2003-2009 онд хийгдсэн судалгааны 56 ажлын талаарх мэдээллүүд орсон болно. Эдгээр судалгаа, шинжилгээний ажлыг салбар, чиглэлээр нь ангилж үзвэл Ашигт малтмалын чиглэлээр 31, Эрчим хүчний чиглэлээр 2, Төмөр зам, авто замын чиглэлээр 2, байгаль орчин, экологийн чиглэлээр 6, Салбарын хүний нөөц бүрдүүлэлт, боловсон хүчин 3, Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэсэн хот суурингийн чиглэлээр 9, уул уурхайн үйлдвэрлэлийн усан хангамжийн чиглэлээр 3 судалгааны ажил хийгджээ.

ХОТЖИЛТЫН БОДЛОГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

<i>Судалгааны код:</i>	СТ-10/407
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Чулуун, Ю.Эрдэнэтуяа, Б.Буяндэлгэр
<i>Захиалагч:</i>	УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
<i>Огноо:</i>	2010.02.10
<i>Сэдвийн агуулга:</i>	Хот тосгоны эрх зүйн байдал, хот тосгоны хөгжил нь монголын нийгмийн хөгжлийн нарийн төвөгтэй асуудлын нэг юм.87 Тиймээс, Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлогын гол үндсэн тулгуур баримт бичгүүдэд хот тосгоны хэтийн хөгжлийг тэтгэхэд чиглэсэн агуулгаар олон тодорхой заалт орсон байдаг. Тэдгээрийг холбогдох хууль тогтоомжийн агуулгаас түүвэрлэсэн.

Хууль эрх зүйн зохицуулалтын “анхаарал татсан” заалтууд, харьцуулалтанд Хот тосгоны эрх зүйн байдалд холбогдох хууль тогтоомжийн эргэлзээтэй гэж үзэж болохуйц зарим заалтыг “... шинэчилсэн найруулгын төсөл”-д тодорхой хэмжээгээр холбон хамаатуулж тухайлан сонирхохыг зорьсон болно.

ХОТ, ТОСГОНЫ ТАЛААР БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АСУУДЛУУД, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-10/409

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Б.Ариунжаргал

Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв

Огноо: 2010.02.10

Сэдвийн агуулга: Дэлхий нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байгаа асуудлын нэг нь хотжих үйл явц юм. НҮБ-аас хүн амын хэт төвлөрөл, хотжих үйл явцаас гарах сөрөг үр дагаврыг хязгаарлах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах асуудлын хүрээнд XXI зуунд баримтлах стратеги чиглэлийг тодорхойлсон баримт бичгүүд гаргасан байна.

Манай орны хувьд хот сууринд шилжих явц харьцангуй хурдацтай явагдаж, хүн амын 1/3 хувь нь нийслэл хотод төвлөрч үүний хэрээр томоохон хотуудын экологийн тэнцвэрт харьцаа алдагдаж, өөр бусад сөрөг олон асуудлууд гарах болсон зэргээс шалтгаалан хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоог боловсронгуй болгох, бүс нутгуудын тэнцвэртэй хөгжлийг хангах, хот суурингийн талаар төрийн бодлого, зохицуулалт шаардлагатай болсныг үндсэн дээр дараах баримт бичгүүдийг боловсруулан гаргасан байна.

ХОТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС

Судалгааны код: СТ-10/410

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: С.Дорждагва, Ц.Түвшинзаяа, Ш.Хишигсүрэн

Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв

Огноо: 2010.02

Сэдвийн агуулга: Дэлхийн хүн ам хот руу нүүн суурьших явц ихээхэн хурдацтай явж байна. 1950 оны үеэс 21 дүгээр зуун хүртэл хүн амын тооны хувьд 4 дахин, нийт хүн амтай харьцуулсан хувиар бол 3 дахин нэмэгдсэн байх юм. 1950 онд нийт хүн амын 30 хүрэхгүй хувь буюу 0.7 тэрбум хүн амьдарч байсан бол 2000 он гэхэд энэ тоо 2.8 тэрбум болж нийт хүн амын 47 хувиас илүү болсон байна.

Энэхүү судалгаанд хотжилтын талаар ерөнхий тойм, хотын тухай ойлголт, хотын байгаль орчны асуудал, хот байгуулалт нь бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбогдох байдал, түүний хүн ам, хөгжлийн асуудал, гадаадын зарим орны (Хятад, Тайвань, Япон, Солонгос, Турк) хотжилтын туршлагыг оруулав.

АЙМГИЙН ТӨВ-ХОТУУДЫН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТАЛААР

Судалгааны код: СТ-10/411

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Д.Золбоо

Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв

Огноо: 2010.02

Сэдвийн агуулга: Өнөөгийн аймгийн төвүүдийн үүсэл нь 1600-аад оноос эхэлж, 1700-аад онуудад нэлээн өргөжин хүрээ, сүм хийд хурал номын газар, улмаар цэргийн хамгаалалт, худалдааны төв, XVIII-XIX зуунд улам бүр засаг захиргааны төв буюу суурин шинж чанартай болон хөгжиж ирсэн байна.

Мэдээлэл лавлагаанд аймгийн төв болох хотуудын үүсэл хөгжил, Дархан, Чойбалсан, Ховд, Эрдэнэт, Цэцэрлэг зэрэг хотуудын өнөөгийн байдал, тулгамдаад буй асуудлуудыг хамруулсан.

ДЭЛХИЙН БОЛОН БҮС НУТАГТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД БОЛОН УУЛ УУРХАЙ, АШИГТ МАЛТМАЛЫН САЛБАРТ МОНГОЛ УЛСЫН БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

<i>Судалгааны код:</i>	СТ-10/414
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Д.Мягмарцэрэн
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Н.Энхболд
<i>Огноо:</i>	2010.07.26
<i>Сэдвийн агуулга:</i>	Мэдээлэл лавлагаанд дэлхийн болон бүс нутгийн уул уурхай, ашигт малтмалын салбарт тулгамдаж буй асуудлууд болох нөөцийн хомсдол, түүхий эдийн үнийн өөрчлөлт зэргийг, ашигт малтмалын салбарт тээвэрлэлт, борлуулалтын талаар Монгол Улсын баримталж буй бодлогыг оруулсан.

ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНӨӨС ҮҮДЭН УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН СУУРЬШИЛТАД БИЙ БОЛСОН ХҮНДРЭЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-10/415
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Б.Буяндэлгэр, О.Нарантуяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Бямбацогт
<i>Огноо:</i>	2010.08
<i>Сэдвийн агуулга:</i>	Мэдээлэл лавлагаанд дэлхийн болон бүс нутгийн уул уурхай, ашигт Бүс нутгийн хөгжлийн ялгавартай байдал, нөөц, бололцоо, үйлчилгээний тэгш бус хүртээмжийн улмаас төвийн бүсийн аймаг, хотууд, ялангуяа нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн сүүлийн 10 гаруй жилд эрчимтэй явагдаж, Монгол Улсын газар нутгийн 0,3 хувийг эзэлдэг нийслэл Улаанбаатар хотод манай орны нийт хүн амын 40 хувь нь оршин сууж байна. Гэтэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн даац судалгаагаар 500 мянган хүн байх тооцоо байдаг атал өнөөдрийн байдлаар 2 дахин олон хүн ам оршин сууж байна. Улаанбаатарын хүн амын механик өсөлт нь хот төлөвлөлт, газар ашиглалт, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамж, байгаль орчны тэнцвэрт байдлыг илт алдагдуулах, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

ХОТ, ТОСГОНЫ АСУУДЛААР ТУЛГАМДААД БАЙГАА АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БОЛОХ САНАЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-10/416
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Хатанбаатар, Б.Буяндэлгэр, Г.Билгээ, Д.Живгаагүнсэл
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир
<i>Огноо:</i>	2010.09.15
<i>Сэдвийн агуулга:</i>	Энэхүү судалгаа нь “Хот тосгоны эрх зүйн зохицуулалтын асуудал”-аар хийсэн бүлэг судалгааг нэгтгэж, дараах асуудлыг шийдэх загварчилсан саналыг санал болгосон. <ul style="list-style-type: none">- Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хот нь нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд ороогүй учраас түүнийг нутаг дэвсгэр засаг захиргааны нэгж байлгахын тулд "сум" болгох хэрэгцээ шаардлага гарч ирсэн.- Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтаар 150.000 хүн амтай дүүргийн статусыг сумтай адилтган үздэг. Гэтэл нэг сум дунджаар 4.400

хүн амтай байна. Энэхүү ялгамжтай байдал нь иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахгүй байгаагийн зэрэгцээ төрийн албанд сөргөөр нөлөөлж байна.

- Монголын хот газрын нийт хүн амын 67,7 хувь нь зөвхөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэтэд хотод төвлөрчээ. 138 сум аймгийн төвөөсөө 50 хүртэл км зайтай алслагдсан, аймаг, сумдын хүн ам харилцан адилгүй (12.000-70.000 хүн амтай). Хөдөө, орон нутгаас хот суурин газар луу шилжих их нүүдэл үргэлжилсэн хэвээр байна.

МОНГОЛ УЛСАД ИМПОРТООР ОРЖ ИРЖ БАЙГАА БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙН ХАМГИЙН ИХ ХЭМЖЭЭТЭЙ 100 НЭР ТӨРЛИЙН БАРАА БОЛОН ТЭДГЭЭРИЙГ ДОТООДОД ОРЛОН ҮЙЛДВЭРЛЭЖ БАЙГАА ҮЙЛДВЭРҮҮДИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-10/417
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Шинэбаяр
Огноо: 2010.09.20
Сэдвийн агуулга: Уг судалгааг хийхдээ Гаалийн Ерөнхий Газраас гаргаж өгсөн “хамгийн их хэмжээтэй” болон “хамгийн их үнийн дүнтэй” гэсэн ангиллаар 2007-2009 оны дүнг авч нэгтгэл хийсний үндсэн дээр уг мэдээлэлд нэр дурдагдсан бараа, бүтээгдэхүүнийг үндсэн 4 бүлэг болгож ангилж авч үзлээ. Үүнд:

1. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн
2. Барилгын материал, түүхий эд
3. Машин техник, тоног төхөөрөмж
4. Бусад (Өргөн хэрэглээ болон бусад бараа материал, түүхий эд)

МОНГОЛ УЛС ДАХЬ ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖИЙН АСУУДАЛ, ХОТ СУУРИНГИЙН УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ, ЭЗЭМШЛИЙН БАЙДАЛ

Судалгааны код: СТ-10/422
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын гишүүн Ж.Батсуурь
Огноо: 2010.11.01
Сэдвийн агуулга: Судалгааг Хүн ам, орон сууцны тооллогын дүн болон Зам тээвэр, Барилга хот байгуулалтын яамны харьяа Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газраас ирүүлсэн мэдээнд тулгуурлан бэлтгэлээ.

Судалгааг Орон сууцны хангамжийн өнөөгийн байдал, Орон сууцны хангамжийн талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилт, Хот суурингийн усан хангамж, ариутгах татуургын өнөөгийн нөхцөл, эзэмшлийн байдал зэрэг асуудлын хүрээнд судлав.

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД УЛСЫН БОЛОН ХУВИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ, ХОГИЙН ҮЙЛДВЭРҮҮДИЙН НЭР

Судалгааны код: СТ-10/423
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Н.Түвшинтөгс, Б.Ариунжаргал
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж
Огноо: 2010.11.19
Сэдвийн агуулга: Уг мэдээлэл лавлагаанд Нийслэлийн тээврийн үйлчилгээний их, дунд, бага оврын автобусны төрөл, насжилтын судалгаа, Буухиа үйлчилгээний тээврийн хэрэгслийн маркийн судалгаа, Таксийн тээврийн хэрэгслийн тоо, төрөл, насжилтын судалгаа, Хот хооронд үйлчилж байгаа нийтийн тээврийн

компаний нэр, тээврийн хэрэгслийн төрөл, тоо, Хот хоорондын такси тээврийн үйлчилгээ эрхэлдэг компаниудын нэр, тээврийн хэрэгслийн тоо, Улс хоорондын байнгын ачаа тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын нэр, тээврийн хэрэгслийн тоо болон яамд, Төр засгийн автобаазын тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл, статистикийг оруулсан.

ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ИРГЭНИЙ НИСЭХИЙН КОМПАНИУДААР ҮЙЛЧЛҮҮЛДЭГ ТОО, ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Судалгааны код: СТ-10/424
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын гишүүн Н.Батбаяр
Огноо: 2010.12.21
Сэдвийн агуулга: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нисэхийн компаниудын дотоод, гадаадын нислэгийн үйлчилгээнд төсвөөс зардлыг нь төлж үйлчлүүлсэн хэмжээ, зардлын дүнгийн талаар мэдээлэл бэлтгэлээ.

Шаардагдах мэдээллийг Сангийн яамны вебсайт, гаргасан тайлангууд, Монголын агаарын тээвэрлэгчдийн холбоо, Иргэний нисэхийн Монгол Улсын харьяат зарим компаниудаас албан бичгээр авсан тойм мэдээлэл, Иргэний нисэхийн ерөнхий газраас гаргасан 2009 оны статистик мэдээлэл, тус газрын вебсайт дахь мэдээллүүдэд тулгуурлан хийлээ.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-10/501
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын гишүүн Х.Баттулга
Огноо: 2010.05.21
Сэдвийн агуулга: Уг судалгаа нь Төмөр замын тээврийн хөгжлийн бодлогын зарим асуудал, Монгол Улсын төмөр замын тээврийн салбарт төрөөс баримталж буй бодлогын баримт бичиг, эрх зүйн зохицуулалт зэрэгт шинжилгээ хийсэн ба Төв Азийн бүсийн тээврийн коридорууд, Евразийн төмөр замын үндсэн коридоруудын зургийг оруулсан.

УИХ-Д ӨРГӨН БАРЬСАН “УТААГҮЙ УЛААНБААТАР” ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Судалгааны код: СТ-10/503
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Бямбацогт
Огноо: 2010.05.21
Сэдвийн агуулга: Дүн шинжилгээнд “Хүний хөгжил сангийн тухай” хуульд нэмэлт оруулах, уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх хувилбарын талаарх судалгаа, дүн шинжилгээ, Монгол Улсын төвлөрсөн төсвөөс хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжийн талаарх тооцоолол болон Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийн санхүүжилтийн таамаглал, тооцоонд үндэслэн гаргасан дүгнэлт, зөвлөмж багтсан.

УИХ-Д ӨРГӨН БАРЬСАН “УТААГҮЙ УЛААНБААТАР” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨЛД ХИЙСЭН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код: СТ-10/504
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, Ч.Базар, Б.Мөнхцэцэг, Б.Ариунжаргал
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Бямбацогт
Огноо: 2010.05.24
Сэдвийн агуулга: УИХ-д өргөн барьсан “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөр нь хэдийгээр 2010-2016 оны хооронд нийт 7 жилийн хугацаанд, харьцангуй богино хугацаанд хийхээр төлөвлөсөн арга хэмжээнүүд байвч хэтэрхий цар хүрээ нь өргөн, ангилж ялгахад төвөгтэй байв. Тухайлбал, "Утаагүй Улаанбаатар" нэртэй боловч "нийслэл рүү чиглэсэн хүн амын шилжилт, суурьшлыг сааруулах, зогсоох, хотын төвлөрлийг буруулах зорилгоор аймаг, бүсийн тулгуур төв, сууринг цогцоор хөгжүүлэх" зорилт тавин орон нутгийг бүхэлд нь хамруулж хөтөлбөрийн хүрээг хэт томруулсан байна.

Иймд хөтөлбөрийн төсөлд тусгасан арга хэмжээнүүдийг дараах 4 чиглэлд хамааруулан судалгааг явууллаа. Үүнд:

- Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон өөрчлөх,
- Тоосжилтыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх,
- Гэр хорооллын дулаан хангамж, түүхий нүүрсний хэрэглээ,
- Автозам, автомашины утааны бохирдлыг бууруулах.

Судалгааны баг дээрх 4 чиглэлээр хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээнүүдийг нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад шууд нөлөөлж чадах эсэх, нөлөөлөх ач холбогдлын байдлаар нь эрэмбэлэх оролдлого хийв.

ОЮУ ТОЛГОЙ ОРДЫН 34 ХУВИЙГ ЭЗЭМШСЭНЭЭР МОНГОЛ УЛСЫН ХҮРТЭХ АШИГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

Судалгааны код: СТ-10/505
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2010.05.24
Сэдвийн агуулга: Судалгаа нь тооцооллыг Монгол Улс уг төслийн 34% эзэмшихээр болсон өнөөгийн нөхцөлд ирээдүйд бий болох үр ашиг хэр хэмжээтэй байхыг тодруулах зорилгоор хийв. Монгол Улс уг төслөөс татвар хураамжийн хэлбэрээр хэдий хэмжээний ашиг олох талаар тусгайлан судалгаа хийгдсэн тул энэ хэсэгт хамруулаагүй болно. Өөрөөр хэлбэл, энэ судалгаа нь уг ордыг ашиглах талаар хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээ байгуулж Монгол Улс хувь эзэмших, тэр тусмаа гэрээнд оролцогч нөгөө тал буюу хөрөнгө оруулагчаас өндөр хүүтэй зээл авч өөрийн эзэмших хувьд хөрөнгө оруулалт хийх, улмаар ногдол ашгаасаа суутгуулах нь хир оновчтой бодлого байсныг эрх бүхий байгууллагаас ирүүлсэн, хүчин төгөлдөр гэрээгээр мөрдөж буй тоон үзүүлэлт дээр суурилан тооцоолж гаргах зорилготой юм.

ОЮУ ТОЛГОЙ ОРДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНД ТУСГАГДСАН ТАТВАРЫН ТӨРӨЛ, ХУВЬ ХЭМЖЭЭ

Судалгааны код: СТ-10/506
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ

Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2010.05.24
Сэдвийн агуулга: Оюу толгой ордын хөрөнгө оруулалтын Гэрээ хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан тус гэрээнд тусгасан тогтворжуулсан татварын төрөл, хувь хэмжээ, татварын нөхцөлд дахин анализ хийхэд энэхүү судалгааны зорилго оршино.

ТАВАН ТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ БОДЛОГЫН ХУВИЛБАР

Судалгааны код: СТ-10/507
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн, Ч.Базар, С.Дорждагва, Н.Түвшинтөгс, Б.Ариунжаргал
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2010.07.07
Сэдвийн агуулга: Судалгаанд Таван толгойн ордыг ашиглахад шаардагдах дэд бүтцийн асуудал, Оюу толгойн ХОГ болон Таван толгойн ордыг ашиглах ХОГ-ний төслийн байгаль орчныг хамгаалах асуудлын харьцуулалт, Таван толгойн уурхайг ашиглах болон Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлагын талаарх харьцуулалтыг багтаасан.
Хөрөнгө оруулалт, орд ашиглалтын хувилбарууд, Хувь эзэмшлийн хэмжээ, талуудад ногдох ашиг орлого, Үйлдвэрлэлийн явцад гарч болох эрсдэлүүд, зайлсхийх арга замын талаар дүгнэлтийг хийж захиалагчид хүргүүлэв.

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛСЭН САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны код: СТ-10/508
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2010.05.24
Сэдвийн агуулга: Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийн төслийн Засгийн газраас өргөн барьсан хувилбарыг УИХ-аар хэлэлцэх явцад гишүүд болон Байнгын хороодыг холбогдох мэдээлэл судалгаагаар хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хуулийн төслийг сайжруулж үзэл баримтлалд дурдсан зорилгыг хангахуйц хэмжээний бодит байдал болон олон улсын жишигт нийцсэн зах зээлийн загвар, хяналт, зохицуулалтын механизмыг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох үүднээс Ажлын дэд хэсгийн гишүүний хувьд дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН СУДАЛГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-11/102
<i>Судалгааны төрөл:</i>	Бодлогын судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Алтан-Оч, Б.Буяндэлгэр, С.Дорждагва, Б.Ариунжаргал
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Бямбацогт
<i>Огноо:</i>	2011.04.14
<i>Сэдвийн агуулга:</i>	Бодлогын судалгаанд (1) Монгол Улсын жижиг, дунд үйлдвэрлэлийн талаар судлагдсан байдал, (2) Монгол Улсад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, өнөөгийн байдал, (3) нийслэл болон хөдөө орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлд хийсэн шинжилгээ, тэднийг дэмжиж хөгжүүлэх эдийн засгийн хөшүүрэг, (4) экспортыг дэмжих бодлогын хэрэгцээ, импортыг орлох үйлдвэрлэлээс давуу болохын учир, (5) жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортод чиглэсэн үйл ажиллагааг дэмжихэд төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар гадаадын зарим орны туршлага (Польш, Чех, Болгар), (6) жижиг, дунд үйлдвэрлэлийн эрх зүйн орчины талаар хөндөж судалсан.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛАЛТ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

<i>Судалгааны код:</i>	СТ-11/206
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Д.Мягмарцэрэн
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ
<i>Огноо:</i>	2011.02.17
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгааг захиалгын дагуу 2006.07.08-ны өдөр батлагдсан “Ашигт малтмалын тухай” хуулийг 1994 оны 9-р сард, 1997 оны 6-р сард тус тус батлагдан мөрдөгдөж байсан “Ашигт малтмалын тухай” хуулиудтай харьцуулах байдлаар гүйцэтгэв.

Мөн “Газрын хэвлийн тухай” хууль, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулиуд болон бусад улс орнуудын холбогдох жишээн дээр уул, уурхайн салбарын хууль эрх зүйн зохицуулалтуудыг харьцуулан судлав.

ХОТЫН ТУХАЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-11/214
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Товуусүрэн, Б.Буяндэлгэр, П.Амаржаргал, Б.Хатантуул
<i>Захиалагч:</i>	УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн
<i>Огноо:</i>	2011.04.28
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгааны багийн судалгаанд хамруулсан Ази, Америк, Африк, Европ тивийн гол төлөв төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсуудын хувьд Үндсэн хуулийн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт хотын тухай заалтууд хэрхэн тусгагдсан талаар харьцуулан судалсан.

НИЙСЛЭЛ ХОТ ДУНДУУР УРСАН ӨНГӨРДӨГ ГОЛ МӨРНИЙ АШИГЛАЛТ, МЕНЕЖМЕНТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

<i>Судалгааны код:</i>	СТ-11/217
------------------------	-----------

Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа, Г.Гэрэл, О.Нарантуяа, Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн П.Алтангэрэл, Д.Кёкүшюзан Батбаяр
Огноо: 2011.05.27
Сэдвийн агуулга:

Энэхүү судалгааны ажилд дэлхийн зарим том гүрнүүдийн нийслэл дундуур урсан өнгөрдөг гол, мөрөн болон бусад усны эх үүсвэр, нөөцийг хамгаалах, сэргээх, зүй зохистой ашиглах туршлагауд, эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

Судалгаанд дэлхийн томоохон улс орнууд болох Их Британи, БНХАУ, БНСУ, ОХУ, Франц улсуудын холбогдох жишээнүүдийг сонгон авлаа. Судалгааны үр дүнгээс харахад, эрх зүйн бүлийн хувьд манай улстай ижил улс орнууд тухайлсан нэг голд зориулсан хууль батлахгүйгээр нийтлэг үйлчлэх Усны тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиараа зохицуулж байна. Нийслэл хот дундуураа урсаж буй гол усаа тогтоол, журам, дүрэм, хөтөлбөр боловсруулах байдлаар хамгаалдаг байна. Харин Англо-саксоны эрх зүйн бүлд хамаарагдах улс орнууд зарчмын өөр зохицуулалттай буюу тухайлсан нэг зүйл, юмс үзэгдэлд зориулан нийтлэг болон нийтлэг бус хэсэгчилсэн байдлаар үйлчлэх хууль тогтоомж батлан гаргадаг тул холбогдох жишээ болгон Их Британийн Лондон хотын дундуур урсах Темза мөрнийг хамгаалах эрх зүйн актын талаар орууллаа.

ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУЮУ МЭРГЭШЛИЙН ХОЛБООДЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХИ ХБНГУ-ЫН ТУРШЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-11/219
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Энхбат
Огноо: 2011.06.15
Сэдвийн агуулга: Судалгаанд үйлдвэр, үйлчилгээний буюу мэргэшлийн холбооны үүрэг зорилго, мэргэшлийн эрхийн биет эвлэл (танхим) буюу эрхийн төлөөллийн байгууллага, мэргэшлийн эрхийн эрхзүй, өөрийн удирдлагын талаар судалсан.

“АЛСЛАГДСАН БҮС” НУТГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДЭНД ОЛГОДОГ ХӨНГӨЛӨЛТ, НЭМЭГДЛИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-11/220
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч
Захиалагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар
Огноо: 2011.06.10
Сэдвийн агуулга: Энэхүү харьцуулсан судалгаанд Бүсчилсэн хөгжлийн бодлогыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд, хэрэгжүүлэх арга хэрэгслүүд, бүсийн нэмэгдэл, түүнийг олгох үндэслэл, олгох хэлбэрүүд болон ОХУ, Канад улсын гадаад орнуудад бүсийн нэмэгдэл олгож буй туршлагын талаар судлав.

ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СТАНДАРТ, ЭРХЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-11/227
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, С.Дорждагва, Ө.Мөнхтунгалаг, Б.Мөнхцэцэг

Захиалагч: УИХ-ын гишүүн Я.Батсуурь
Огноо: 2011.11.05
Сэдвийн агуулга: Харьцуулсан судалгаанд органик хүнс, органик зах зээлийн тухай зарим тоо баримт, олон улсын органик хөдөө аж ахуйн нэгдсэн хөдөлгөөн ба органик хөдөө аж ахуйн зарчмууд болон АНУ-д үндэсний органик хөтөлбөр хэрэгжүүлж буй туршлагын талаар судлав.

БАЙГАЛИЙН ЦЭВЭР ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ, ГАДААДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-11/301
Судалгааны төрөл: Тойм судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун, Ө.Мөнхтунгалаг, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын гишүүн Я.Батсуурь
Огноо: 2011.01.11
Сэдвийн агуулга: Захиалгын дагуу Монголын бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнийг экологийн хувьд цэвэр байлгах чиглэлд гарсан болон гарвал зохих эрх зүйн зохицуулалтын талаар, мөн түүнчлэн, байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн, тухайлбал, мал аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүний чанарын асуудлыг хуульчилсан гадаад орны туршлагад холбогдох тойм мэдээллийг боловсруулав.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, ТАЛУУДЫН ОРОЛЦОО

Судалгааны код: СТ-11/403
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ч.Базар
Захиалагч: УИХ-ын гишүүн П.Алтангэрэл
Огноо: 2011.02.21
Сэдвийн агуулга: Энэхүү мэдээлэл лавлагаанд байгаль орчны хяналт, талуудын оролцоо, экологийн цагдаа, экологийн прокурорын талаарх зарим ойлголт, экологийн чиглэлээр ажилладаг хүчний болон хяналтын байгууллагын талаарх зарим орны туршлага, байгаль орчинг хамгаалах бодлогын чиг хандлага зэрэг асуудлыг хөндөв. Монгол Улс ба Аархусын Конвенцид нэгдэх хэрэгцээ, шаардлага мэдээллүүдийг багтаав. Байгаль хамгаалах талаар дэлхийн улс орнуудын чиг хандлага нь улсын хяналтын тогтолцоонууд байхаас гадна нутгийн иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн зохистой харьцаа буюу талуудын оролцооны үндсэн дээр тогтсон менежментийг явуулснаар байгаль хамгаалах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах гэсэн харьцаа, үйл явц үр дүнтэй байгааг харуулж байна. Энэ талаарх мэдээллийг нилээд түлхүү оруулсан бөгөөд дээрх чиглэлийн үйл ажиллагааг дэмжихэд манай орны эрх зүйн тогтолцоонд зарим нэг өөрчлөлт оруулах нь зайлшгүй байгааг энэхүү мэдээлэл лавлагаанд тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Судалгааны код: СТ-11/415
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Б.Мөнхцэцэг, Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын гишүүн Н.Энхболд
Огноо: 2011.05.15
Сэдвийн агуулга: Монгол Улсын далайн эрх зүйн байдлын тухай мэдээлэлд Монгол Улсад далай ашиглах эрх зүйн орчин бүрдсэн байдал, Далайн тээврийн салбарын эрх зүйн өнөөгийн нөхцөл байдал, **Далайд гарцгүйгээс үүдсэн**

бэрхшээлүүд, Бодлогын хувьд анхаарах асуудлын судласан бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон болон нэгдэн орохоор төлөвлөж байгаа олон улсын Конвенци болон тэдгээрийн Протоколуудын лавлагааг оруулсан.

МОНГОЛ УЛСАД ИМПОРТООР ОРЖ ИРЖ БУЙ ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ (2005-2011 он)

Судалгааны код: СТ-11/417

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

Захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Шинэбаяр

Огноо: 2011.08.15

Сэдвийн агуулга:

Монгол Улсын импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний талаарх лавлагаа мэдээллийг дараахь бүтэцтэйгээр хийж гүйцэтгэлээ. Нэгдүгээр хэсэгт, Монгол Улсын гадаад худалдааны импортын өнөөгийн байдал болон импортын бараа бүтээгдэхүүнд голлох байр суурь эзэлж буй бүтээгдэхүүнийг сонгон сүүлийн 5 жилийн хугацаан дахь динамик үзүүлэлтийг гаргалаа.

Дараагийн хэсэгт, Гадаад худалдааны статистик үзүүлэлтээс импортын бараа бүтээгдэхүүнд хамаарах ойлголтууд, импортоор орж ирж буй гол нэрийн бараа бүтээгдэхүүний сонголт болон тэдгээрээс гол нэрийн 50 бараа бүтээгдэхүүний жагсаалтыг 2005-2011 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан болно. Мөн түүнчлэн гадаад худалдааны өнөөгийн байдлын мэдээллийг тоймлон хүргүүлж байна.

ТАВАНТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО БА ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ОЛОН НИЙТИЙН САНАЛ ШҮҮМЖ

Судалгааны код: СТ-11/418

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Д.Мягмарцэрэн, Ч.Базар, Ц.Батдорж, С.Дорждагва, Б.Дуламсүрэн, Б.Мөнхцэцэг, Ч.Онончимэг, Н.Түвшинтөгс, Ц.Элбэгзаяа

Захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Шинэбаяр

Огноо: 2011.10.20

Сэдвийн агуулга:

Энэхүү сэдвийн хүрээнд УИХ-ын 39 дүгээр тогтоолын хэрэгжилтийн үр дүн болон орд ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар олон нийтээс санал болгож буй хувилбар зэргийг нэгтгэн лавлагаа мэдээллийн хэлбэрээр бэлтгэв. Судалгааны үр дүнд Тавантолгойн нүүрсний орд ашиглалтын талаар төрөөс баримталж буй өнөөгийн бодлогын хүрээнд уг ордыг Монгол Улсад үр өгөөжтэйгээр ашиглаж чадах эсэх, энэ талаар олон нийт ямар саналтай байгаа зэргийг тодруулахыг зорьсон болно. Судалгаа нь дараах бүтэцтэй:

- Тавантолгойн ордыг ашиглах талаар төрөөс баримталж буй бодлого, холбогдох шийдвэрүүд
- УИХ болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээ, хийгдсэн ажлууд
- Таван толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний зарчим, хэрэгжилт
- Тендерт оролцогч, шалгарах магадлал бүхий гадаадын хөрөнгө оруулагч компаниуд
- Ордын ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар төрийн болон олон нийтийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдын санал болгож буй хувилбарууд гэсэн үндсэн хэсгүүдтэй.

ДЭЛХИЙН ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ КОМПАНИЙН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦОО

Судалгааны код:	СТ-11/422
Судалгааны төрөл:	Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач:	Г.Билгээ
Захиалагч:	УИХ-ын гишүүн Д.Одхүү
Огноо:	2011.11.22
Сэдвийн агуулга:	Лавлагаа-мэдээлэлд дэлхийн 32 орны (Азийн – 16, Америк – 4, Африк – 5, Европ – 7) төрийн өмчийн оролцоотой 37 компанийг хамруулсан болно. 100 хувь төрийн өмчийн компани нь нийт компанийн 57 хувийг эзэлж байгаа бол 30 хувь нь 50-90 хувь нь төрийн өмчийн компани байна. Харин үлдсэн буюу 13 хувь нь 50-аас бага хувьтай төрийн өмчийн компани эзэлж байна.

ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БОДЛОГО ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код:	СТ-11/504
Судалгааны төрөл:	Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач:	Ц.Товуусүрэн, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа, Ө. Мөнхтунгалаг, С.Дорждагва
Захиалагч:	УИХ-ын гишүүн Ч.Улаан
Огноо:	2011.10.20
Сэдвийн агуулга:	<p>Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлого эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ судалгааны ажлын хүрээнд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн байдлын талаархи нэгдсэн мэдээллийг тоймлон гаргаж Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эдийн засагт эзлэж буй байр суурийг тодорхойлох, улмаар энэ салбарын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч тулгамдсан асуудлуудыг тодруулах зорилго тавив.</p> <p>Судалгааны “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний өнөөгийн байдлын тойм” хэсэгт тус салбарт хэрэгжиж байгаа эрх зүйн баримт бичгүүд, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал цаашид хийгдэхээр төлөвлөгдсөн ажлын хийсэн дүн шинжилгээг тоймлон оруулав.</p> <p>“Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын статистик мэдээлэл” хэсэгт Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт улсын хэмжээнд нийт хэдэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн үйл ажиллагаа явуулж байгаа талаархи нэгдсэн тоо баримтыг гаргахыг зорьж ҮСГ-ын жилийн болон улирлын статистик мэдээлэл, Худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар дүн шинжилгээ хийсэн.</p> <p>“Судалгааны дүгнэлт, санал, зөвлөмж” хэсэгт судалгааны мэдээлэлд үндэслэн тус салбарын хэмжээнд анхаарал татсан асуудлуудыг тодорхойлж, мэргэжлийн байгууллагууд болон мэргэжилтнүүдээс гаргасан саналуудыг багцлан тусгав.</p>

2012 ОН

ХОРШООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код:	СТ-12/205
Судалгааны төрөл:	Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач:	Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Ц.Батдорж, Ц.Болормаа, Б.Дуламсүрэн, Д.Мягмарцэрэн, Ч.Онончимэг
Захиалагч:	УИХ-ын гишүүн Н.Энхболд

Огноо: 2012.04.11
Сэдвийн агуулга: НҮБ-ын Ерөнхий ассамблейн 64-р чуулганаас 2012 оныг “Олон улсын хоршооллын жил” болгон зарласан. Өнөөдөр дэлхийн долоон тэрбум хүний гурван тэрбум нь хоршооноос ашиг хүртэж, 100 сая ажлын байрыг бий болгосон байна. Манай улсын хувьд, 1990-ээд оны үед сум нэгдэл гэж байснаа задарч, хоршооллыг байгуулсан ч энэ нь төдийлөн үр дүнтэй ажил болж чадаагүй. Харин сүүлийн жилүүдэд иргэд бизнесийн салбарт ахиухан мөнгөгүй л бол ганцаарчилсан тоглолт хийгээд үр дүнгүй гэдгийг ойлгож байгаа тул, хоршоолол байгуулах хандлага нэмэгдсэн. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 2000 орчим хоршоо үйл ажиллагаа явуулж буй бөгөөд ирэх жилээс энэ тоо улам нэмэгдэх хандлагатай байна.

НҮҮРСНИЙ АНГИЛАЛ, ЭКСПОРТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ, ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-12/208
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, Б.Дуламсүрэн, Б.Нарантуяа, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2012.05.18
Сэдвийн агуулга: Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу нүүрс олборлолт болон экспортын хэмжээгээр тэргүүлэгч улс орнуудаас Австрали, АНУ, Индонез, ОХУ, Өмнөд Африк, Хятад улсуудыг сонгон авч нүүрсний ангилал, нөөц, экспортын хэмжээ, экспортын болон бусад татварын хувь хэмжээ зэрэг асуудлын хүрээнд Монгол Улсын нүүрсний экспортын өнөөгийн байдалтай харьцуулан авч үзсэн болно.

ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ, АШИГЛАЛТЫН ЯВЦ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ГАДААДЫН УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-12/217
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, С.Дорждагва
Захиалагч: УИХ-ын гишүүн, АБГББХ-ны дарга Я.Батсуурь
Огноо: 2012.08.02
Сэдвийн агуулга: Судалгаанд цөмийн энергийн талаар олон улсын конвенцид төрийн байгууллагуудын оролцоо, үүргийн талаар тусгасан байдал гэсэн эхний хэсэгт эрх зүйн зохицуулалт хийх, хэрэгжүүлэх, хянахтай холбоотой асуудлууд, хүрээлэн буй орчны хамгаалал, иргэдийн хяналт, оролцоог хангахтай холбоотой асуудлууд, зах зээлд хяналт тавих, хайгуул, олборлолт, ашиглалтад төр өөрөө оролцохтой холбоотой асуудал зэргийг хамруулан судалсан ба хоёр дахь хэсэгт цацраг идэвхт хаягдлыг (цих) булж хадгалах байгууламж барих оон улсын зохицуулалтын талаар судалсан.

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХӨНГӨЛӨЛТ, ДАВУУ ТАЛ ОЛГОДОГ ЭСЭХ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-12/218
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг, Б.Хатантуул
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2012.08.17

Сэдвийн агуулга: УИХ-ын гишүүн Д.Ганхуягийн 2012 оны 7-р сарын 27-ны өдрийн 326 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу дэлхийн улс орнууд тендерт оролцож буй үндэсний аж ахуй нэгжүүддээ ямар хэлбэрээр хөнгөлөлт үзүүлдэг талаар туршлагыг харьцуулсан судалсан бөгөөд судалгааг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн эдийн засгийн багийнн судлаачид хийж гүйцэтгэлээ.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-12/219
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р. Хатанбаатар, А. Пагма, Г.Гэрэл
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат
Огноо: 2012.09.11
Сэдвийн агуулга: Гадаадын зарим орны, тухайлбал, Хятад, Молдавын хот байгуулалтын харилцааг зохицуулсан хуулийг Монгол Улсын “Хот байгуулалтын тухай” хуультай харьцуулалт хийн, давуу болон сул талыг гаргаж, цаашид манай орны онцлогт тохируулан авч хэрэгжүүлж болох туршлага, эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан дүгнэлт гаргасан. Мөн зарим өндөр хөгжилтэй орнуудын хот байгуулалтын эрх зүйн орчны талаархи мэдээллүүдийг нэгтгэн нийтлэг асуудал, эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг ерөнхийлөн харуулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТ, ТҮҮНИЙ ДЭГЛЭМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БУСАД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-12/228
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Товуусүрэн, Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын гишүүн Су.Батболд, Сү.Батболд
Огноо: 2012.11.20
Сэдвийн агуулга: Энэхүү судалгаа нь Монгол Улсын Хилийн боомт, түүний дэглэмийн өнөөгийн нөхцөл байдал, Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн боомтын дэглэмийг зохицуулж байгаа гэрээ, хэлэлцээр, эрх зүйн актууд, дотоодын хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн боомтын эрх зүйн орчин, Европын холбооны улсуудын хилийн дэглэмийг судлахад чиглэгдсэн болно.

Европ тивийн улс орнуудын хамтын ажиллагааны хэлбэрүүд, Европын холбооны улсуудын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд европын холбоонд нэгдэхгүй байх, тодорхой хязгаартай нэгдэх, холбоонд үл хамаарахтай холбогдсон зохижуулалт, визийн ялгааг онцолж сонгон авч үзсэн болно. Түүнчлэн Европын холбооны хэмжээнд мөрдөгдөж байгаа хилийн зохицуулалттай холбоо бүхий эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалтыг хавсаргав.

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРД"-ЫН ХУУЛЬ ЗҮЙН ТОДОРХОЙЛОЛТ, АШИГТ МАЛТМАЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-12/229
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2012.11.28

Сэдвийн агуулга: Судалгааны явцад Америк, Беларус, Хятад, Индонез, Казахстан, Канад, Орос, Энэтхэг зэрэг орнуудын ашигт малтмалын хуулиудыг харьцуулан судалсан болно. Судалгаанд хэд хэдэн орны хуулийг авч үзсэн боловч “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газар” гэсэн нарийвчилсан хуулийн тодорхойлолт төдийлөн олдоогүй тул нэр бүхий орнуудаар судалгааны хүрээг хязгаарлав. Судалгаанд авагдсан орнуудын стратегийн ашигт малтмалын ордын тодорхойлолт, зарим орнуудын ашигт малтмалын төрөл зүйлийн ангилалыг судалгаагаар харуулав.

ТӨРИЙН НИЙТИЙН ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-12/404
Судалгааны төрөл: Лавлагаа мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Ө.Мөнхтунгалаг, Б.Хатантуул, Д.Живгаагүнсэл
Захиалагч: Тамгын газар
Огноо: 2012.05.29
Сэдвийн агуулга: Дээрх судалгаанд холбогдох хууль эрх зүйн баримтууд, мэдээлэл, судалгааны материалд үндэслэн төрийн нийтийн өмчийн тухай үндсэн ойлголт, Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн лавлагаа болон төрийн нийтийн өмчийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх мэдээллийг багтаасан болно.

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙРНЫ ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-12/412
Судалгааны төрөл: Лавлагаа мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун, Ц.Батдорж
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл
Огноо: 2012.12.10
Сэдвийн агуулга: Судалгааны ажлын явцад “Сууц өмчлөгчдийн холбоо, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн эрх зүйн байдлын тухай хууль” болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийн явцад бий болж буй тулгамдсан асуудлуудыг тодруулах, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл болон иргэд оршин суугчдаас гарч буй санал шүүмжүүдийг харьцуулан судлах, бусад сайн туршлага бүхий зарим орнуудын /ОХУ, Казахстан/ орон сууцны нийтийн өмчлөлийн эрх зүйн зохицуулалтын актууд болон төрөөс явуулж буй бодлого зэргийг харьцуулан судалж дүгнэлт гаргах зорилго тавив.

Судалгаанд Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл болон БХБЯ-ны ОСНАА-н Бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн албан ёсны тоо мэдээлэл, өдөр тутмын сонин хэвлэл, вэб сайтуудад гарсан Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаатай холбоотой санал шүүмжүүд зэргийг эх сурвалж болгон ашигласан ба эдгээр мэдээллийг нэгтгэн дүгнэлт гаргав. Мөн ОХУ, БНКУ-ын холбогдох хууль тогтоомжуудыг ашиглав.

БНХАУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХЗҮЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Судалгааны код: СТ-12/413
Судалгааны төрөл: Мэдээлэл давлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Д-р Г.Алтан-Оч

Захиалагч: УИХ-ын гишүүн, БОХХААБХ-ны дарга Г.Баярсайхан
Огноо: 2012.12.11
Сэдвийн агуулга: Энэхүү мэдээлэл лавлагаанд БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн зохицуулалтын талаар судалж оруулсан.

ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ АГУУЛГА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код: СТ-12/504
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн (МА), Ч.Онончимэг, Д.Байгальмаа, Ц.Батдорж
Захиалагч: УИХ-ын гишүүн Б.Гарамгайбаатар, Д.Тэрбишдагва, С.Ганбаатар
Огноо: 2012.05.07
Сэдвийн агуулга: “Оюу толгой” төслийн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний шинжилгээ болон “Оюу толгой”-н ордын 34 хувийг эзэмшснээр Монгол Улсын хүртэх ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжид шинжилгээ хийв.

Дүн шинжилгээний хавсралтад “Оюу толгой” төслийн хөрөнгө оруулалтын гэрээний танилцуулга, татварын нөхцөл, эрх зүйн харьцуулалт, Гэрээгээр тогтворжуулсан татваруудын талаархи лавлагаа, “Оюу толгой” хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан татвар ногдох орлогоос хасагдах зардлууд, хөнгөлөлтүүд хуульд нийцсэн эсэх, “Оюу толгой” хөрөнгө оруулалтын гэрээ ба хууль хоорондын нийцэл, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд 2000 оноос хойш оруулсан өөрчлөлт зэрэг хавсралт судалгаанууд багтсан.

ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ТАТВАРЫН НӨХЦӨЛ, ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-12/505
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ц.Болормаа, Б.Дуламсүрэн
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2012.05.07
Сэдвийн агуулга: Оюутолгойн ордыг ашиглахаар Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу Майнз Монголия Инк ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед нарын хооронд байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний татварын орчныг харьцуулан судлав. Гэрээгээр тогтоосон тогтворжуулсан болон үл тогтворжуулсан татварын нэр төрөл, хувь хэмжээг тухайн үед Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хууль тогтоомжууд болон Засгийн газраас УИХ-д 2009 онд өргөн барьж байсан өмнөх гэрээний төсөлтэй тус тус харьцуулсан.

БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/101
<i>Судалгааны төрөл:</i>	Бодлогын судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Алтан-Оч
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн, ӨБХ-ны дарга Р.Бурмаа, УИХ-ын гишүүн Х.Болорчулуун
<i>Огноо:</i>	2013.10.08
<i>Сэдвийн агуулга:</i>	“Бүтээгдэхүүн хуваах гэрээ” сэдэвт бодлогын судалгааны бичвэрт газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд дэлхий даяар зонхилон хэрэглэдэг бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай ерөнхий ойлголт, зардлын тос болон ашгийн тосны хувь хэмжээ, тэдгээрийг засгийн газар, гадаадын нефтийн компанийн хооронд хуваах зарчим, хуваарилалтын бүтэц, роялти хураамж буюу ашигт малтмалын татварын хэмжээ, түүнтэй хослуулан албан татварын хэмжээг уян хатан тогтоосноор гэрээний үр ашигт хэрхэн нөлөөлөхийг шинжилсэн дүн, гэрээний бусад үзүүлэлтүүдийн тухай тайлбар, ашигт малтмалын салбарт хэрэглэдэг гэрээнүүдийн төрөл, тэдгээрийн ялгаа, газрын тос, байгалийн хийнээс бусад салбарт уг гэрээг ашигласан тухай олон улсын туршлагыг тус тус тусгасан болно.
<i>Хайлтын түлхүүр үг:</i>	бүтээгдэхүүн хуваах гэрээ, газрын тос, байгалийн хий, түүхий нефть, зардлын тос, ашгийн тос, роялти, ашигт малтмалын татвар, урамшуулал, дотоод борлуулалтын үүрэг, оролцоо

ЦЭНГЭГ НУУРЫН ХАМГААЛАЛТЫН ТАЛААРХИ ГАДААД УЛС ОРНЫ ЭРХЗҮЙН [ЗАРИМ] ЗОХИЦУУЛАЛТ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/204
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Алтан-Оч, Г.Чулуун
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Г.Баярсайхан
<i>Огноо:</i>	2013.01.22
<i>Сэдвийн агуулга:</i>	Цэнгэг нуурын хамгаалалтын талаархи гадаад улс орны эрх зүйн зохицуулалт (АНУ, Канад, ОХУ-ын туршлагаас жишээлсэн лавлагаа)

ГҮНИЙ УСНЫ АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ТУРШЛАГА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/205
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Алтан-Оч, Г.Чулуун
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Г.Баярсайхан
<i>Огноо:</i>	2013.01.22
<i>Сэдвийн агуулга:</i>	Гүний усны ашиглалт хамгаалалтын эрх зүйн зохицуулалт, гадаадын туршлага (ОХУ, Украин улсын жишээн дээр)

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ҮНЭ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/206
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа, Д.Байгалмаа, Г.Гэрэл Ч.Онончимэг

Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2013.01.23
Сэдвийн агуулга: Судалгаанд нийт 97 оронд борлуулагдаж буй 4 төрлийн шатахууны /АИ-92, АИ-95, АИ-98 болон ДТ/ жижиглэнгийн үнийг 2012 оны эцсийн байдлаар харьцуулан гаргасан. Судалгаанд хамруулсан 97 орноос АНУ, Англи, Япон, Канад, Норвеги, Франц, Итали зэрэг улсуудын жижиглэнгийн үнийн бүтцэд задлан шинжилгээ хийн, жижиглэнгийн үнийн бүрдүүлэлт, түүний бүтцийн ерөнхий зураглалыг гаргасан болно.

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР (РОЯЛТИ) БА МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛБӨР

Судалгааны код: СТ-13/209
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Алтан-Оч, Ц.Болормаа, Д.Байгалмаа, Г.Гэрэл Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2013.02.04
Сэдвийн агуулга: Судалгаанд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /Роялти/-ийн ерөнхий ангилал, тэдгээрийн давуу болон сул тал, нийт 27 орны ашигт малтмалын төрөл зүйлээс шалгаалсан татварын хувь хэмжээг харьцуулан судалсан. Мөн ашигт малтмалын менежментийн төлбөрийн эдийн засгийн агуулгын ойлголт, түүнийг тооцох суурь тооцоо, Латин Америкийн зарим орнуудын менежментийн төлбөрийн хувь хэмжээний талаарх туршлагыг авч үзсэн.

ӨСӨН НЭМЭГДЭХ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, ДЭЛХИЙН УЛСУУДЫН ЖИШИГ

Судалгааны код: СТ-13/211
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Гэрэл, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2013.02.25
Сэдвийн агуулга: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /роялти/-ийн төрөл, хэлбэр түүнээс хамаарсан төлбөрийг ногдуулах арга зам, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тогтолцооны давуу ба сул тал, чиг хандлагын талаар судалгаанд авч үзлээ.
Мөн түүнчлэн өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, төлбөрийн нөхцөлийн талаар Аргентин, Австрали, Чили, Хятад, Энэтхэг, Перу, Өмнөд Африк зэрэг орнуудыг хамруулан судалсан болно.

БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ /ЛОМБАРД/-НИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/214
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Байгалмаа
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл
Огноо: 2013.03.06
Сэдвийн агуулга: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа ломбардуудын бүртгэл, үйл ажиллагаа, эрх зүйн орчны өнөөгийн байдал, мөн олон улсын хэмжээнд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг хэрхэн зохицуулж байгаа талаарх туршлагыг харьцуулан судлахыг зорьсон. Судалгааны явцад Улаанбаатар хотын 10 орчим ломбардуудаас асуулга судалгааны аргаар тодорхой хэмжээний мэдээлэл цуглуулсан бөгөөд ЦЕГ-аас 2013 оны 2 сарын

байдлаар нэгтгэл хэлбэрээр ломбардуудын тоог оруулсан. Мөн судалгаанд ОХУ, Герман, Украин зэрэг орнуудад барьцаалан зээлдүүлэх үйлчилгээг хэрхэн зохицуулж байгаа талаарх мэдээллийг харьцуулан судлав.

ГАЗРЫН ТОСНЫ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ БОЛОН ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ИМПОРТЛОЖ БУЙ ОРНУУДЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭ

Судалгааны код: СТ-13/215
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Байгалмаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2013.04.08
Сэдвийн агуулга: Судалгаанд газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний гадаад худалдааны талаар дараах мэдээллүүдийг гаргав. Үүнд:

- Дэлхийн улс орнуудын газрын тосны нөөцийн хэмжээ болон газрын тосны бүтээгдэхүүн импортлогч орнуудын жагсаалт, тэдгээрийн импортын хувь хэмжээний талаарх лавлагаа мэдээлэл;
- Газрын тос импортлогч тэргүүлэгч орнуудын газрын тосны импортын талаар баримталж буй гадаад худалдааны бодлого, өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл;
- Газрын тос импортлох үйл ажиллагааг улс орнууд ямар бүтцээр, хэрхэн зохион байгуулдаг, тухайн улсын төрийн өмчийн оролцоо ямар түвшинд байгаа зэрэг лавлагаа мэдээлэл;
- Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч улс орнуудад учирч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэж буй арга замуудын талаар.

Газрын тос импортлогч, газрын тосны нөөц ихтэй орнуудыг хамруулсан бөгөөд БНХАУ, ОХУ, Швейцари зэрэг орнуудын газрын тос импортлох үйл ажиллагаа, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй гадаад худалдааны бодлогын талаар товч танилцууллаа.

ЛОГИСТИКИЙН СИСТЕМ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/221
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
Огноо: 2013.06.25
Сэдвийн агуулга: Логистикийн гол асуудал нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, зорилтод нийцүүлэн аливаа түүхий эд, бараа, үйлчилгээ, мэдээлэл, санхүүгийн хөрөнгийг эхлэл цэгээс зорилтот цэг хүртэл хамгийн үр ашигтай шилжүүлэлт ба хадгалалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын нэгдмэл процесс юм. Судалгаанд логистикийн систем, хөгжлийн чиг хандлага, түүнчлэн ХБНГУ, ОХУ, БНСУ болон Япон улсын логистикийн эрх зүйн онцлог зохицуулалтыг харьцуулан судалсан.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАМПУУРЛЫН УЛМААС ҮҮССЭН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/228
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Байгалмаа, Г.Гэрэл
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
Огноо: 2013.06.18

Сэдвийн агуулга:

Энэхүү судалгаанд АНУ, Япон улсын банк, санхүүгийн байгууллагын хямрал болон тэдгээрийг дампуурахад Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар, мөн дампуурлаас урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байсан талаар судалсан болно. АНУ-ын санхүүгийн байгууллагуудын хямралыг судлахдаа хадгаламж, зээлийн хоршоод болон хадгаламжийн байгууллагуудын хямралын талаар голлон тусгасан. Харин Япон улсын хувьд банк санхүүгийн байгууллагуудын хямралын үед авах арга хэмжээг нийтлэг байдлаар зохицуулсан нь ажиглагдаж байв.

БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРОНД ...

Судалгааны код:

СТ-13/229

Судалгааны төрөл:

Харьцуулсан судалгаа

Гүйцэтгэсэн судлаач:

Г.Чулуун

Захиалагч:

УИХ-ын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга

Огноо:

2013.07.10

Сэдвийн агуулга:

Судалгаанд, бэлчээрийн зохицуулалтын талаарх хаанахын ямар (улсын) хууль тогтоомжийг сонирхвол илүү өгөөжтэй зохистойг бодолцож, хөрш зэргэлдээ, байгалийн ойролцоо бүс бүслүүр нутагт орших, аль болох бэлчээрийн мал маллагаатай тийм газар орны хууль тогтоомжийг тэргүүн ээлжинд авч үзэхийг чухалчилсан, ө. х., БНХАУ (Өвөрмонголын өөртөө засах орон), Казахстан, Кыргызстан, Тажикстан, Казахстан (хуулийн төсөл), Австралийн бэлчээрийн эрхзүйд холбогдох зохицуулалтуудыг тухайлан авч үзжээ. Бэлчээрийн эрхзүйн талаархи энэ судалгаа дотроо дэд нэр бүхий дэд хэсгүүдтэй, хавсралттай, нийт 17 хууд. юм.

ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код:

СТ-13/233

Судалгааны төрөл:

Харьцуулсан судалгаа

Гүйцэтгэсэн судлаач:

Д.Байгалмаа, Ц.Элбэгзаяа

Захиалагч:

УИХ-ын гишүүн Д.Бямбацогт

Огноо:

2013.09.30

Сэдвийн агуулга:

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлдвэржүүлэлттэй холбоотой доорх асуудлын хүрээнд энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Үйлдвэржүүлэлтийн бодлогын асуудлууд
 - Үйлдвэржүүлэлтийн бодлогын стратеги
 - Үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгслүүд /АНУ, Герман, Франц, Японы жишээн дээр/
 - Үйлдвэрлэлийн ангилал /жигжиг, дунд, том үйлдвэр гэсэн ойлголтыг ямар хүрээнд тодорхойлдог болох/
 - Аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн шалгуур үзүүлэлт
- Үйлдвэржүүлэлтийн бодлого, төлөвшлийн түүхэн замнал, өнөөгийн үйлдвэрлэл
- Гадаадын зарим улс орнуудын үйлдвэржүүлэлтийн туршлагаас /Чех, Польш, Солонгос, Тайвань, Сингапур/

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ГАЗРЫН ТОСНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код:

СТ-13/237

Судалгааны төрөл:

Харьцуулсан судалгаа

Гүйцэтгэсэн судлаач:

Г.Билгээ, Ч.Онончимэг

Захиалагч: УИХ-ын гишүүн, ЭЗБХ-ны дарга Б.Гарамгайбаатар
Огноо: 2013.10.16
Сэдвийн агуулга: Судалгаанд газрын тосны олон улсын хууль тогтоомжийн ангилал, хамрах хүрээ, гадаадын зарим орны газрын тосны эрх зүйн зохицуулалт /Норвеги, Казахстан, Орос/, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ /газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд дэлхий даяар зонхилон хэрэглэдэг бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай ерөнхий ойлголт, зардлын тос болон ашгийн тосны хувь хэмжээ, тэдгээрийг засгийн газар, гадаадын нефтийн компанийн хооронд хуваах зарчим, хуваарилалтын бүтэц, роялти хураамж буюу ашигт малтмалын татварын хэмжээ, түүнтэй хослуулан албан татварын хэмжээг уян хатан тогтоосноор гэрээний үр ашигт хэрхэн нөлөөлөхийг шинжилсэн дүн, гэрээний бусад үзүүлэлтүүдийн тухай тайлбар, ашигт малтмалын салбарт хэрэглэдэг гэрээнүүдийн төрөл, тэдгээрийн ялгаа, газрын тос, байгалийн хийнээс бусад салбарт уг гэрээг ашигласан тухай олон улсын туршлага/-г тус тус тусгасан болно.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ, ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/238
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Живгаагүнсэл, Ц.Болормаа, Г.Билгээ
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, Л.Болд
Огноо: 2013.10.31
Сэдвийн агуулга: Судалгаанд эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлж байгаа болон хөгжлийн түвшингээр манай улстай ойролцоо зэрэг зарим нөхцөл байдлыг харгалзан ОХУ, БНКазакстан Улс, БНБеларус Улс, БНСерби Улс, Доминиканы БНУ, БНХАУ, БНСУ, БНТурк Улс, Тайвань, Малайзын Холбооны Улс зэрэг 10 орныг сонгон авч холбогдох хууль эрх зүйн орчинг харьцуулан судлав. Мөн Монгол Улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийв.

МОНГОЛЧУУДЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, БЭЛЧЭЭРИЙН .. ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ ХИЙСВЭР АСУУДАЛ

Судалгааны код: СТ-13/301
Судалгааны төрөл: Тойм судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга
Огноо: 2013.06.20
Сэдвийн агуулга: Монголд газар өмчлөлийн .. хууль гараад багагүй хугацаа өнгөрчээ. Гэсэн ч нийслэл .. суурин газарт хүртэл газар өмчилсөн хүний тоо өнөөг хүртэл чамлалттай хэвээр байгаа. Малын бэлчээрийг малчдад эзэмшүүлэх, өвөлжөөг өмчлүүлэх асуудал нь шийдвэр гаргах дээд түвшинд энэ хугацаанд хэдэнтээ сөхөгдсөн ч хуульчлагдаагүй юм. Хөдөөний малчид ядаж өвөлжөөний газраа ч болов өөрийн болгоод авчих сонирхолтой байдаг ч судалгаа тандалтаар бэлчээрийг дундын эзэмшил хэлбэрээр үнэгүй ашиглах уламжлалт арга (сонирхол) давамгайлсаар явж ирэв. Бэлчээрийг маргаан гэж нэг “байнгын зовлон” бас бий. Тиймээс, малын бэлчээрийг эзэмшиж ашиглаж ирсэн монгол түмний уламжлалт арга ухаан ямар байсан, яаж өөрчлөгдөж “хөгжиж” ирснийг энэ судалгаа (нийт 17 хууд. мат.)-нд олон талаас нь харж нэгтгэн тоймложээ.

ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНЫ ХИЛИЙН БООМТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЪЯАЛАЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/405
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Товуусүрэн, Ө.Мөнхтунгалаг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн М.Батчимэг
<i>Огноо:</i>	2013.02.15
<i>Сэдвийн агуулга:</i>	Дэлхийн зарим улс орны хилийн боомтын асуудал эрхлэх байгууллагууд, тэдгээрийн харьяаллын талаар судалсан.

ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ГАРЦ, ТЕХНОЛОГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/406
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Д.Байгалмаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
<i>Огноо:</i>	2013.04.08
<i>Сэдвийн агуулга:</i>	Газрын тосны үйлдвэрлэл, ялангуяа үйлдвэрлэлийн технологи, гарц, хүчин чадал, уламжлалт бус эх үүсвэрийн талаарх судалгааг хийхэд шинжлэх ухааны нэр томъёо, үг хэллэг, онолын мэдлэг зэрэг нарийн мэргэжил, мэдлэг чадвар ихээхэн шаардагдах тул асуудлыг гүнзгийрүүлэн судлах нь өрөөсгөл юм. Иймд мэдээллийн эх сурвалжуудыг ашиглан орчин үеийн газрын тосны үйлдвэрлэлийн талаарх ерөнхий мэдээллийг тойм байдлаар танилцуулж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/410
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Хатанбаатар, А.Пагма, Р.Оргилмаа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл
<i>Огноо:</i>	2013.06.03
<i>Сэдвийн агуулга:</i>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль, эрх зүйн актуудын дагуу зохион байгуулж байгаа байдлын танилцуулга, “замын зураглал” болон бодит байдал дээр Засгийн газрын худалдан авах ажиллагаа хэрэгжиж байгаа байдлын жишээн дээр уг мэдээлэл, лавлагааг бэлтгэсэн.

ЛОГИСТИКИЙН СҮЛЖЭЭНИЙ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/416
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Билгээ, Ч.Онончимэг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Г.Батхүү
<i>Огноо:</i>	2013.07.30.
<i>Сэдвийн агуулга:</i>	Монгол Улсын хууль тогтоомжид тээвэр, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгааны дулаан дамжуулах шугам, бараа бүтээгдэхүүний агуулах, тээврийн нэгдсэн логистикийн сүлжээний асуудлыг Олон Улсын гэрээ, конвеци, Монгол Улсын хууль тогтоомжийн гол заалт, зохицуулалтын эрх зүйн мэдээллийг оруулсан.

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, БҮС НУТГУУДАД ХУВААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/417
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Энх-Амгалан, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар
Огноо: 2013.09.23.
Сэдвийн агуулга: Судалгаанд дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж ирсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын арга, зохицуулалт, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт, бүсчилсэн хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж ирсэн арга, төрийн зохицуулалтын асуудлууд, бүс нутгийн хөгжлийг дэмжих институцийг бүрдүүлэх асуудлуудыг тусгасан болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНГЭЭХ ЧАДВАР, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны код: СТ-13/425
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Энх-Амгалан, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар
Огноо: 2013.09.23.
Сэдвийн агуулга: Уг лавлагаа мэдээллийн судалгааны бичвэрт “шингээх чадвар” гэж чухам юуг хэлдэг, тухайн асуудалтай холбогдох судалгааны бусад чиглэлүүд юу болох, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадварыг тодорхойлох, түүнд нөлөөлөх хүчин зүйлс юу болох, Монгол Улсын төсвийн болон гадаадын хөрөнгө оруулалтын шингээх чадварыг хэрхэн тодорхойлсныг тоймлон товчилж тусгасан болно.
Хайлтын түлхүүр үг: шингээх чадвар, аж ахуйн нэгжийн шингээх чадвар, хөрөнгө оруулалтын шингээх чадвар, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадвар, хүний нөөцийн баялаг, санхүүгийн зах зээлийн тогтолцоо, технологи нэвтрүүлэлт, технологийн болон байгууллын түвшин

ОФФШОР БҮСИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ГЭР БҮЛ, ҮР ХҮҮХЭД ОФФШОР БҮСЭД ДАНС НЭЭХ, ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХТАЙ ХОЛБООТОЙ ОХУ-ЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/426
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей
Огноо:
Сэдвийн агуулга: Оффшор/offshore гэдэг нь («эргийн гадна», «хилийн гадна» гэсэн англи үгнээс гаралтай) татвар төлөвлөлтийн хамгийн түгээмэл, үр дүнтэй аргын нэгд тооцогддог. Энэхүү аргын гол зарчим нь гадаад эзэмшигчтэй компаниудыг татвараас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх явдал юм. Ийм төрлийн эрх зүйн зохицуулалттай 60 шахам орон байх ба тэдгээрийн санал болгож байгаа татварын таатай нөхцөл, эрх зүйн баталгааг гадаадын хөрөнгө оруулагчид ашиглах сонирхол их байдаг байна.

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Судалгааны код: СТ-13/502
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Ө.Мөнхтунгалаг

Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат
Огноо: 2013.02.06
Сэдвийн агуулга: Агаарын бохирдлыг бууруулах, түүнчлэн Улаанбаатар хотыг утаагүй болгох чиглэлээр авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүн, зарцуулсан хөрөнгөнд дүн шинжилгээ хийж, агаарын бохирдлоос үүдэлтэй хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй өвчлөл, нас баралтыг статистик тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийсэн.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИН ДЭХ ШИЙДВЭР ГАРГАЛТЫН “ЗАМЫН ЗУРАГ”, ЗАРЦУУЛЖ БУЙ ХУГАЦААНЫ ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-13/504
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма, Р.Оргилмаа
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл
Огноо: 2013.06.03.
Сэдвийн агуулга: Засгийн газраас тогтоол, шийдвэр гаргах процессын эрх зүйн орчин, мөрдөгдөж буй дүрэм, журмын талаарх мэдээлэл лавлагаа гаргах, шийдвэрийг Засгийн газраар эцэслэн гаргах хүртэлх шат, дамжлагууд болон дамжлага бүр дээр зарцуулагдаж байгаа хугацааг тодорхой асуудлын жишээн дээр судлах, Засгийн газрын “засаглалын технологийн” өнөөгийн үйлчилж байгаа “замын зураг”-ыг тодорхойлон гаргасан.